



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 04 өдөр


Дугаар A/04

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Музейн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, Соёлын сайд аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний 4 дүгээр зүйлийн 4.3 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төв музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн бэлтгэл ажлыг хангах, судалгаа боловсруулалтын ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Музейн үзүүллэг дэглэлтийн бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн A/148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА 
П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
01 дугаар сарын 04 ны өдрийн
А/О дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар - (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Батбилгүүн - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Оюунтуяа - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Г.Базар- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Л.Батцэцэг - (Аймгийн Соёл урлагийн газрын дарга)

Х.Баасансүрэн - (Аймгийн Соёл урлагийн газрын Соёлын хэлтсийн дарга)

Ц.Эгиймаа- (Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан,доктор)

Х.Рагчаа - (Аймгийн Төв музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Шинжлэх ухааны академи- зөвшилцлөөр

Соёлын өвийн үндэсний төв - зөвшилцлөөр

Үндэсний музей - зөвшилцлөөр

Чингис хаан Үндэсний музей - зөвшилцлөөр

Байгалийн түүхийн музей - зөвшилцлөөр

Богд хааны ордон музей - зөвшилцлөөр

Х.Баасанхүү - (Аймгийн Төв музейн Сан хөмрөгч)

Д.Зулзаяа - (Аймгийн Төв музейн Бүртгэл мэдээллийн санч)

Нарийн бичгийн дарга:

М.Одмаа - (Аймгийн Төв музейн Эрдэм шинжилгээний ажилтан)

-----оо-----